



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Монгол улс, НҮБ-ын хамтын ажиллагаанд шинэ үе эхэлж байна

Монгол улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллага “НҮБ-аас Монгол улсад 2017-2021 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ”-ний баримт бичигт гарын үсэг зурав

2016 оны 6 дугаар сарын 3, Улаанбаатар хот, Гадаад хэргийн яам - НҮБ-аас Монгол улсад 2017-2021 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” баримт бичигт Гадаад хэргийн сайд Л. Пүрэвсүрэн болон Монгол дахь НҮБ-ын Суурин зохицуулагч Биата Транкман нар гарын үсэг зурлаа. Ийнхүү ирэх таван жилд НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ батлагдсанаар Монгол Улс, НҮБ-ын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой шинэ үе шат эхэлж байна.

“НҮБ-аас Монгол Улсад 2017-2021 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” нь Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) болон Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилтуудыг ханган, үйл ажил болгоход хувь нэмэр оруулах зорилготой баримт бичиг юм. Хүрэх үр дүн, хэрэгжүүлэх арга зам болон хэрэгжилтийг хянах тогтолцоог мөн тодотгож өгсөн энэхүү бодлогын баримт бичгийг дээрх ТХЗ хөтөлбөр болон “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-тай нягт уялдуулж хэлэлцүүлэх, боловсруулахад манай Засгийн газрын холбогдох яамд, агентлаг, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид идэвхтэй оролцсон. Монгол Улсын Засгийн газар, Монгол дахь НҮБ-ын багтай хамтран энэхүү Хөгжлийн тусламжийн хүрээнд тусгасан зүйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагаа, зохицуулалт, үр дүнг ханган ажиллах үүрэг хүлээж байна” хэмээн Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн онцлон тэмдэглэв.

Тус Хөгжлийн тусламжийн хүрээнд **Байгалийн нөөцийн хүртээмжтэй өсөлт, тогтвортой менежментийг дэмжих, Нийгмийн хамгааллыг сайжруулах, чанартай, тэгш нийгмийн үйлчилгээг дэлгэрүүлэх, Олон нийтийн дуу хоолой, тайлагнах зарчмыг бэхжүүлэх** гэсэн 3 үндсэн чиглэлийг баримтлах бөгөөд нийт **79 сая ам.долларын** хөгжлийн тусламжийг Монгол Улсад үзүүлнэ.

НҮБ-ын Суурин зохицуулагч Биата Транкман “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтууд, 2030 хүртэлх Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зорилтуудад хүрэхийн төлөө үйл ажиллагааг уялдуулан эртнээс эрчимтэй, нягт хамтран ажиллахад НҮБ-ын системийн хувьд Хөгжлийн тусламжийн хүрээ нь маш чухал боломж” гэдгийг дурдлаа. Тэрээр “Тогтвортой хөгжлийн зорилтууд нь цогцоор хэрэгжүүлэх, их хүчин чармайлт шаардах учир бидэнд, НҮБ-д хөгжил дэвшлийн төлөө өөрөөр бодох, ажиллах шаардлага тулгарч байна. Бид нийгмийн бүх хэсгийн оролцоог хангахын төлөө олон салбар, бүлгийн хүрээнд хамтран ажиллах хэрэгтэй болно. Ажлын байр бий болгох, инновац шинэчлэлийг нэвтрүүлэхэд хувийн хэвшил хөгжлийн гол хөдөлгүүр байх, түүнчлэн Засгийн газартай хамтран хөгжлийн санхүүжилтийн шинэ загварыг бий болгоход түншлэлийн шинэ арга зам хэрэгтэй байна” хэмээн албан ёсны арга хэмжээнд хэлэв.

Дараагийн 5 жилд хөгжлийн тусламжийн хүрээнд тусгасан үр дүнд хүрэхэд НҮБ-ын төрөлжсөн 14 байгууллага хувь нэмрээ оруулах бөгөөд хамтарсан хөтөлбөр, төсөл, санаачлагыг дэмжин нэгэн багийн хувьд туршлага, мэдээлэл, мэргэжил, арга зүйн дэмжлэгийг нэгтгэн ажиллана. Түүнчлэн тус тусын үйл ажиллагааны чиглэл, мандатын хүрээнд улс орныг дэмжих хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

Ёслолын арга хэмжээнд Монгол дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон ГХЯ-ны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга Б. Баттунгалаг зэрэг албаны бусад төлөөлөгч оролцлоо.

“НҮБ-аас Монгол улсад 2017-2021 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” –ний баримт бичгийн бүрэн хувилбарыг дараахь цахим хаягаар үзэх боломжтой: www.un-mongolia.mn